



## Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: Этүгэн Их Сургууль

Хөтөлбөрийн нэр: Программ хангамж

Индекс: D061302

Шинжээчийн баг:

Ахлагч: Ц.Ганбат (Отгонтэнгэр Их Сургуулийн дэд профессор, доктор)

Гишүүд: Д.Оргил (ХААИС-ийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн  
ахлах багш, доктор)

А.Отгонбаяр (ICT group ХК-ын салбарын захирал)

Он сар өдөр: 2023.06.04

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

**Товчилсон үгийн тайлбар**

- АСМ Association for Computing Machinery
- БШУ Боловсрол Шинжлэх Ухаан
- БМИУЗ Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
- ЭИС Этүгэн Их Сургууль
- ИЭЗМС Инженерчлэл, Эдийн Засаг, Менежментийн сургууль
- СБЗА Сургалтын Бодлого Зохицуулалтын Алба
- ӨҮТ Өөрийн үнэлгээний тайлан
- УМС Удирдлагын мэдээллийн систем
- ЭЕБС Этүгэн Ерөнхий Боловсролын Сургууль
- ПХ Программ хангамж
- БНХАУ Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- ЕШ Ерөнхий шалгалт

**I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Этүгэн Их сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Программ хангамж, бакалаврын хөтөлбөр	
<b>Индекс</b>	061302	
<b>Шинжээчид</b>	Ц.Ганбат (Отгонтэнгэр Их Сургуулийн дэд профессор, доктор) Гишүүд: Д.Оргил (ХААИС-ийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн ахлах багш, доктор) А.Отгонбаяр (ICT group ХК-ын салбарын захирал)	
<b>БМИУЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн</b>	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч Б.Оюунцэцэг	
<b>Төлөвлөгөө</b>	2023.05.16	Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх
	2023.05.25	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх
	2023.05.26	Сургуулийн бэлэн байдлыг нягтлах
	2023.05.30,31	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2023.06.09	Шинжээчийн баг зохицуулагчид шинжээчийн тайланг илгээх

		Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
		Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах
<b>Шалгуур шаардлага /журам/</b>		БМИУЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Гуравдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав.

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Зорилго: Хүн чанартай, мэргэжлийн ёс зүйтэй, үндэсний болон олон улсын дээд боловсролын ажил олгогчдын шалгуур шаардлагыг хангасан, программ хангамжаар мэргэшсэн, харилцааны өндөр ур чадвартай, компьютерын ухааны чадварлаг мэргэжилтэн бэлтгэхэд оршино

Хөтөлбөрийн хүрэх үр дүн PLOs (Program Learning Outcomes)

### Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, чадвар, хандлага

#### 1. Мэргэжлийн мэдлэг, сэтгэлгээ

1. Мэргэжлийн шинжлэх ухааны үндсэн суурь мэдлэг
  - I. Математик, статистик тооцооллууд, логик уялдаа холбоо, энтрепенёр сэтгэлгээ, бизнес төслийн талаарх мэдлэг эзэмших
  - II. Компьютерын техник үндэс, бүтэц зохион байгуулалт, ажиллах зарчим, сүлжээний орчин болон холболтын талаарх мэдлэг эзэмших
  - III. Программ хангамж, программчлалын онолын үндэс, ажиллах зарчим, веб болон объект хандалт технологийн тухай мэдлэг эзэмших
  - IV. Өгөгдөл, түүний дүрслэл, бүтэц болон систем, системийн шинжилгээ, зохиомж, загварчлалын тухай мэдлэг эзэмших

#### 2. Мэргэжлийн цөм мэдлэг

- I. Үйлдлийн систем болон системийн программ хангамж, өгөгдлийн сан, түүний зохиомж, интерфейс зохиомж, байгууллагын нөөцийн системийн мэдлэг эзэмших
- II. Мэдээллийн аюулгүй байдал, программ хангамжийн загвар гаргах, хэрэгжүүлэх тухай мэдлэг эзэмших
- III. Сүлжээний орчны программ хангамж, хөдөлгөөнт холбооны систем ба программчлалын мэдлэг эзэмших

#### 3. Ахисан түвшинд мэргэших боломж

- I. Хосолсон болон хөрвөх мэргэжил
  1. Программ хангамж+Мэдээлэл зүйн багш /багц цаг судлаад/
  2. Программ хангамж+Компьютерын сүлжээ /багц цаг судлаад/
  3. Программ хангамж+Мэдээллийн систем/багц цаг судлаад/
- II. Багшлах эрхийн сургалтад суралцаж, багшлах
- III. Боловсролын чиглэл
  1. Бакалаврын боловсролтой программ хангамжийн мэргэжилтэн нь бизнесийн болон техникийн ухааны чиглэлээр 2-оос доошгүй жил суралцаж магистрын зэрэг хамгаалж болно.

2. Магистрын боловсролтой программ хангамжийн мэргэжилтэн нь 3-аас доошгүй жил суралцаж боловсролын докторын (Doctor of Philosophy) зэрэг горилж болно.
3. Докторын боловсролтой программист нь шалгуур хангавал ШУ-ны докторын зэрэг (Doctor of Science) горилж болно.

## **2. Хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, хандлага**

4. Шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх чадвар
  - I. Байгууллагын үйл ажиллагаа, мэдээлэл технологийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх чадвар эзэмших
  - II. Байгууллагын мэдээлэл технологийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох чадвар эзэмших
  - III. Шийдвэрлэх арга замыг сонгох, хэрэгжүүлэх чадвар эзэмших
  - IV. Гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх чадвар эзэмших
5. Туршилт хийх, мэдлэг бүтээх чадвар
  - I. Мэдээлэл технологийн үйлчилгээний хамрах хүрээ чанар, үр нөлөөг дээшлүүлэхтэй холбогдсон системийн шинжилгээ хийх чадвар эзэмших
  - II. Системийн загвар боловсруулах чадвар эзэмших
  - III. Программын кодыг логик уялдаа холбоотой бичих чадвар эзэмших
  - IV. Программын кодыг шалгах чадвар эзэмших
6. Системтэйгээр бодох чадвар
  - I. Мэдээлэл технологийн өөрчлөлт шинэчлэлтэд болон мэдээлэл технологийн өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагаанд нийгэм, эдийн засаг, улс төрийн орчны үзүүлж буй нөлөө тэдгээрийн үр дагаварт үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар эзэмших
  - II. Тухайн байгууллагын зорилго, зорилтод нийцүүлэн мэдээлэл технологийн хөгжлийн стратегийг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах чадвар эзэмших
  - III. Хэрэглэгчдийн санал шүүмжлэлийн мөрөөр зохих ажлыг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чадвар эзэмших
  - IV. Мэдээлэл технологийн аюулгүй байдлын талаарх хууль тогтоомж, стандартыг судалж түүнд нийцүүлсэн бүтээгдэхүүн гаргах чадвар эзэмших
7. Хувь хүний хандлага, байнга суралцах чадвар
  - I. Зорилгоо тодорхойлох
  - II. Үүрэг хариуцлагаа ухамсарлах, цагийг үр дүнтэй ашиглах чадвар эзэмших
  - III. Харилцагчтай харилцахдаа ялгаварлалгүй үйлчлэх чадвар эзэмших
  - IV. Хувь хүн өөрийгөө хөгжүүлж, мэдлэг туршлагаа байнга сайжруулах чадвар эзэмших
  - V. Мэргэжилдээ дур сонирхолтой, насан туршдаа суралцах, мэргэжлээрээ өсөн дэвших хандлага төлөвших
  - VI. Байгууллагын дотоод журмын дагуу зөв дүр төрх бүрдүүлэх чадвар эзэмших
  - VII. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг дагаж мөрдөх чадварыг эзэмших
8. Ёс зүйтэй байх, хариуцлагаа ухамсарлах чадвар
  - I. Мэргэжилтний ёс зүйн дүрмийг чанад сахих: Ёс зүйн өндөр соёл, ёс суртахуунтай байж, аливаа хууль бус үйл ажиллагааны нөлөөлөлд авталгүй нийтийн эрх ашигт нийцүүлэх, ёс зүйн зөрчил, маргаантай асуудлаас урьдчилан сэргийлэх, үүрэг хариуцлагаа хүлээх
  - II. Хүн бүрд тэгш хандах, үл ялгаварлах: Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй, үйлчлүүлэгч бүрд адил тэгш хандах

- III. Хариуцлагатай байх, боловсорч хөгжих: Хөдөлмөрч, хичээнгүй, даруу төлөв, нямбай, мэргэжлийн ур чадвартай байх, насан туршдаа сурч боловсорч, мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлэх

### **3. Хүмүүстэй харилцах, багаар ажиллах ур чадвар**

#### **9. Багаар ажиллах**

- I. Харилцан ойлголцох: Багийн гишүүд бие биеэ сонсохын зэрэгцээ өөрийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадвар эзэмших
- II. Харилцан итгэлцэх: Өөртөө болон багийн гишүүддээ итгэх чадвар эзэмших
- III. Хариуцлага хүлээх: Багийн гишүүн бүр хариуцлага хүлээж, түүндээ итгэлтэй хандах хандлага төлөвших
- IV. Урам, дэмжлэг: Харилцан бие биеэ дэмжиж урамшуулах чадвар эзэмших

#### **10. Харилцааны ур чадвар**

- I. Бусдыг сонсох чадвар эзэмших
- II. Өөрийн үзэл бодол байр сууриа зөв илэрхийлэх чадвар эзэмших
- III. Харилцагчдадаа асуудлаа шийдвэрлэхэд нь зөвлөн туслах чадвар эзэмших
- IV. Бичгийн харилцааны чадвар эзэмших /алдаагүй, цэвэр нямбай гаргацтай бичих/

#### **11. Гадаад хэлээр харилцах чадвар**

- I. Цахим сургалтын орчинд яриа, видеог гадаад хэл дээр сонсож, ойлгох чадвар
- II. Мэргэжлийн дагуух сурах бичиг, нэр томъёо, зааврыг зэргийг ойлгох, ашиглах чадвар
- III. Гадаад хэлээр харилцах харилцааны чадвар

### **4. Салбар болон нийгэмд чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадвар**

#### **12. Мэргэжилтэн гаргах шийдвэрийнхээ үр нөлөөг (орчин ба нийгмийн хүрээнд) ойлгох чадвар**

- I. Программ хангамжийн инженерийн мэргэжлийн зорилго, үүргийг тодорхойлох
  - 1. Программ хангамж болон техникийн үйл ажиллагаа байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөг судлах
  - 2. Программ хангамжийн бүтээгдэхүүн зохиох, хэрэглээ болгох
  - 3. Мэдээлэл технологийн тоног төхөөрөмж нь байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөлд шинжилгээ хийх
- II. Программ хангамжийн мэргэжилтний үйл ажиллагааны холбогдох дүрэм, журмыг ойлгох
  - 1. Мэдээлэл технологи, программ хангамж, мэдээллийн аюулгүй байдлын хууль, дүрэм журам, стандарттай танилцах
  - 2. Оюуны өмчийг бүтээх, ашиглах, хамгаалах аргуудын судлах Мэргэжлийн байгууллагуудын стандартуудыг мөрдөх
- III. Инженерийн үйл ажиллагааны хүрээнд даяарчлалын нөлөөг тодорхойлох

#### **13. Мэргэжилтэн гаргах шийдвэрийнхээ үр нөлөөг (эрүүл мэнд, тусламж үйлчилгээ болон бизнесийн хүрээнд) ойлгох чадвар**

- I. Зохиосон программ нь хүний эрүүл мэнд, сэтгэл зүй, орчинд хэрхэн нөлөөлөхийг тооцох чадвартай байх
- II. Зохиосон программын бизнесийн хүрээнд үйлчлэх чадвартай байх
  - Бизнесийн зорилго, орчинг тодорхойлох
  - Бизнесийн төрөл хэлбэрийг ойлгох
  - Өөрийн бизнест хэрэглэх
- III. Мэдээлэл технологийн салбарт хэрэгжүүлж болохуйц бизнес боломжуудыг судлах

Шинэ бүтээгдэхүүн ба системийг бий болгох

Үйлдвэрийн санхүү, зохион байгуулалтын бүтцийг бий болгох

#### **14. Мэргэжлийн болон удирдлагын түвшинд сэтгэн бодох чадвар**

- I. Зах зээлийн эрэлт, боломжийг тодорхойлох  
Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж дүгнэх  
Байгаль орчноос үүсэх хэрэгцээг тодорхойлох
  - II. Зорилгыг тодорхойлогч загварын системтэй байх  
Техникийн гүйцэтгэлийн тохирох загварыг тодорхойлох Хэрэгжүүлж  
ажиллуулах үндсэн үзэл баримтлалыг харуулах  
Янз бүрийн зорилго, функц, үзэл баримтлал, бүтэц зардлуудаас сонгох
15. Үйл ажиллагааг төлөвлөх чадвар
- I. Шинжилгээ хийх чадвар эзэмших
  - II. Зохион бүтээх чадвар эзэмших
  - III. Төслийн төлөвлөгөөг боловсруулах чадвар эзэмших
  - IV. Оновчтой мэдээллээ эрж хайх, нэгтгэн дүгнэх, ялгах чадвар эзэмших
  - V. Байгууллагын зорилго, үйл ажиллагаанд нийцүүлэн мэдээлэл технологийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хүрэх үр дүнг төлөвлөх чадвар эзэмших
16. Хэрэгжүүлэх, бүтээх чадвар
- I. Асуудал, бодит байдал, боломж, зорилгыг тодорхойлох чадвар эзэмших
  - II. Тухайн системийн үйл ажиллагааг нарийвчлан судлах чадвар эзэмших
  - III. Системийн хэрэгцээ, шаардлагад анализ хийх чадвар эзэмших
  - IV. Цуглуулсан өгөгдөл, мэдээллийг ашиглан мэдээллийн системийн логик зохиомжийг гаргах чадвар эзэмших
  - V. Программ Хангамжийг хөгжүүлэх ба баримтжуулах чадвар эзэмших
  - VI. Системийг тестчилэх ба сайжруулах чадвар эзэмших
  - VII. Java, c++, C# хэлүүдийг ашиглаж программ бүтээх /Веб сайт бүтээх, төсөл бичих, системийн шинжилгээ хийх, программ тестлэх, дотоод болон гадаад сүлжээ тавих, албан бичиг боловсруулах, сервер зохион байгуулах чадвар эзэмших
17. Хэрэглээ болгох чадвар
- I. Хуучин системийг шинэ системд хөрвүүлэх загварыг сонгож, системийг хөрвүүлэх чадвар эзэмших
  - II. Шинэ системийг суурилуулан хэвийн ажиллагааг хангах чадвар эзэмших
  - III. Шинэ системийн хөгжүүлэлтийг тасралтгүй хийх чадвар эзэмших
  - IV. Программ хангамжийн ашиглалтын үзүүлэлт, программ хангамж ба техникийн баримт бичгийг бүрдүүлэх чадвар эзэмших
18. Мэргэжлийн манлайлал
- I. Шинийг эрэлхийлэгч, санаачлагч, бүтээгч байх чадвар эзэмших
  - II. Удирдан зохион байгуулах чадвартай байх чадвар эзэмших
  - III. Дүн шинжилгээ хийж, тайлагнах чадвар эзэмших
19. Энтэрпренёршип
1. Шинэ санаа гаргах, шинийг эрэлхийлэх хандлага төлөвших
  2. Судалгаа хийх, төсөл бичих чадвар эзэмших
  3. Гарааны бизнес эхлүүлэх чадвар

#### Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives)


1. Программ хангамж хөтөлбөрөөр бэлтгэгдсэн мэргэжилтэн нь байгаль, нийгмийн ухаан, программчлалын суурь мэдлэг чадварыг эзэмшүүлсэн байх.
2. Программ хангамжийн хөтөлбөр нь онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлэх, бие даан хөгжүүлэх, асуудлыг шийдвэрлэхдээ системтэйгээр тунгаан бодох, хувийн болон мэргэжлийн авьяас чадвараа хөгжүүлэх чадварыг эзэмшүүлсэн байх.
3. Мэдээлэл технологийн асуудлыг бие даан турших, судлах, тооцоолох, шийдвэрлэх, мэргэжлийн сэтгэлгээ, ур чадварыг бүрэн эзэмшүүлэх.

4. Ажлын байранд янз бүрийн түвшний хүмүүсээс бүрдсэн баг хамт олонтой хамтран ажиллах, харилцааны ёс зүйтэй, хариуцлагатай, хувийн зохион байгуулалт сайтай хувь хүн болгон төлөвшүүлэх.
5. Программ хангамжийн хариуцах ажлын хүрээнд асуудлыг төлөвлөх, хэрэгжүүлэх чадвартай, гадаад хэлний мэдлэгтэй, цаашид дараагийн шатны сургалтуудад гадаад болон дотоодод суралцах чадвартай, мөн үндэсний хэмжээний, цаашлаад олон улсын хэмжээний их дээд сургуулийн шаардлагуудыг бүрэн хангасан мэргэжилтэн бэлтгэх

### Хөтөлбөрийн төгсөгчийн загвар

ЭИС-ийн алсын хараа, эрхэм зорилгын дагуу хөтөлбөрийн хүрэх үр дүн (PLO)-г “(1) мэргэжлийн мэдлэг сэтгэлгээ, (2) хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, хандлага, (3) хүмүүстэй харилцах, багаар ажиллах ур чадвар, (4) салбар болон нийгэмд чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадвар” гэсэн 4 бүлэг ур чадвар, шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон

### Хөтөлбөрийн зорилго, зорилт



### Сургалтын төлөвлөгөөний бүтэц

Код	Англи нэршил	Монгол нэршил	Кредит	Улирал
<b>1. Ерөнхий суурь</b>				
<b>1.1. Заавал судлах хичээлүүд</b>				
ETH101, ETH102	Communication ethics and law	Харилцааны ёс зүй, эрх зүй	4	I
HIS101	Mongolian history, culture and customs	Монголын түүх соёл, ёс заншил	2	II
PHY101	Physics	Физик	3	I



INF101	Information Technology and Information Systems	Мэдээллийн технологи, мэдээллийн систем	3	II
ESE108	Mongolian language and stylistic writing	Монгол хэл бичиг, найруулга зүй	3	II
ESE103	Engineering Mathematics	Инженерийн математик	3	I
ESE104	Hardware	Техник хангамж	2	VIII
<b>1.2. Сонгон суралцах хичээлүүд</b>				
ESE112	Ecological and environmental protection	Экологи, байгаль хамгаалал	3	III
ESE113	Disaster Management	Гамшгийн менежмент	1	I
ESE114	English Language	Англи хэл	3	I
ESE118	Primary care	Анхан шатны тусламж	2	I
ESE119	Psychology Basics	Сэтгэл судлалын үндэс	2	II
PHE101	Physical Education	Биеийн тамир	1	I
ENT101	Entrepreneur	Энтрепренёр	1	IV
PHI101	Mental history and Cultural Studies Basics	Сэтгэлгээний түүх, соёл судлалын үндэс	3	II
<b>2. Мэргэжлийн суурь хичээл</b>				
<b>2.1. Заавал судлах хичээлүүд</b>				
ESE201	Computer Networks I	Компьютерын сүлжээ I	2	III
ESE202	Computer Networks II	Компьютерын сүлжээ II	2	IV
ESE203	Data Structures	Өгөгдлийн бүтэц	3	II
ESE204	Information System Basics	Мэдээллийн системийн үндэс	2	III
ESE205	Internet Programming I	Интернэт программчлал I	3	IV
ESE206	Internet Programming II	Интернэт программчлал II	3	V
ESE208	Algorithm Basics	Алгоритмын үндэс	2	I
ESE209	Programming Language	Программчлалын хэл	2	II
ESE219	Communication Skills I, II	Харилцааны ур чадвар I, II	2	III, IV
ESE221	Survey Methodology	Судалгааны арга зүй	2	IV
ESE222	Probability Theory and Matematik Statistics	Магадлалын онол математик статистик	3	IV
ESE223	Computational Mathematics	Тооцон бодох математик	3	V

## 2.2. Сонгон суралцах хичээлүүд

ESE210	Project Management	Төслийн менежмент	2	IV
ESE212	Computer Graphics	Компьютерын график	3	II
ESE213	Computer Organization and Assembly Language	Компьютер зохион байгуулалт, ассемблер хэл	3	VII
ESE214	Discrete Mathematics	Дискрет математик	3	IV
ESE216	Mathematical Programming	Математик программчлал	3	V
ESE224	Mathematic Logic	Математик логик	2	III

## 3. Мэргэжлийн хичээлүүд

### 3.1. Заавал судлах хичээлүүд

ESE301	Database Programming	Өгөгдлийн сангийн програмчлал	2	III
ESE302	Enterprise Resource Planning System (ERP)	Байгууллагын нөөцийн систем - ERP System	2	VI
ESE303	Human-Machine Interaction	Хүн машины харилцаа	2	III
ESE304	Information Security	Мэдээллийн аюулгүй байдал	3	VIII
ESE305	Java technology	Жава технологи	3	V
ESE306	Mobile device programming I	Хөдөлгөөнт төхөөрөмжийн програмчлал I	2	V
ESE307	Mobile device programming II	Хөдөлгөөнт төхөөрөмжийн програмчлал II	2	VI
ESE309	Operating System	Үйлдлийн систем	3	VI
ESE310	Software Architecture And Quality Assessment	Программ хангамжийн архитектур ба чанарын үнэлгээ	3	VII
ESE311	Software Requirements Analysis	Программ хангамжийн шаардлагын шинжилгээ	2	IV
ESE314	System Programming	Системийн програмчлал	2	VI
ESE315	Visual Programming	Визуал програмчлал	3	III
ESE320	Software Project	Программ хангамжийн төсөл	3	VI
ESE326	Professional English	Мэргэжлийн англи хэл	3	VI
ESE327	Professional Ethics I, II	Мэргэжлийн ёс зүй I, II	2	V, VI
GBP101	Business Project	Бизнес төсөл	1	VI

ESE328	Object Oriented Programming	Объект хандлагат программчлал	3	III
ESE332	System Analysis and Design UML Language	Системийн шинжилгээ ба зохиомж UML хэл	3	V
ESE335	Programming Language Python	Пайтон программчлалын хэл	3	V
<b>3.2. Сонгон суралцах хичээлүүд</b>				
ESE308	Mobile communication system GSM, GPRS and UMTS	Хөдөлгөөнт холбооны систем GSM, GPRS, UMTS	2	V
ESE312	IT Special Group I - Network Cisco Program	Мэдээллийн технологийн тусгай бүлэг I - Сүлжээ Cisco хөтөлбөр	2	VIII
ESE313	IT Special Chapter II - Software Project	Мэдээллийн технологийн тусгай бүлэг II - Программ хангамжийн төсөл	2	VII
ESE316	Visual software Project	Визуаль программ хангамжийн төсөл	2	VI
ESE317	Web software Project	Веб программ хангамжийн төсөл	2	V
ESE220	Fundamentals of electronics	Электроникийн үндэс	2	IV
ESE323	Intelligent system	Ухаалаг систем	2	VI
ESE324	Network management	Сүлжээний удирдлага	2	V
ESE329	Unix programming	UNIX программчлал	2	IV
ESE338	Innovation and Technology	Инновац ба технологи	2	VI
ESE343	Artificial Intelligence and Machine Learning	Хиймэл оюун ба машин сургалт	3	VII
<b>4. Дадлага</b>				
ESE333	Programming practice I	Программчлалын дадлага I	2	VI
ESE334	Programming practice II	Программчлалын дадлага II	2	VII
<b>5. Шалгалт</b>				
ESE330	Creative employment /Diploma Project /	Бүтээлч ажил /Дипломын төсөл/	3	VIII
ESE331	Integrated theory test II	Онолын нэгдсэн шалгалт	-	VIII

Багшлах бүрэлдэхүүний нөөц, чадамж

*Ерөнхий суурь хичээлийн багш нар*

№	Овог нэр	Үндсэн мэргэжил	Эрдмийн цол, зэрэг	Сургуульд ажилласан жил	Мэргэжлийн байгууллагад ажилласан жил	Заах хичээл
1	Б.Батсэрээдэн э	Хүний их эмч	доктор	20	32	Харилцааны ёс зүй, эрх зүй
2	С.Нямзагд	Эдийн засагч	доктор	20	50	
3	Т.Батзул	Математикийн багш	доктор	6	30	Магадлалын онол Математик логик
4	А.Цэцэгмаа	магистр	Магистр	1	34	Англи хэл
5	П.Баярмаа	Математик, мэдээлэл зүйн багш	Магистр	11	11	Инженерийн математик Мэдээллийн технологи, мэдээллийн систем
6	Н.Отгонбаяр	Багш	Докторант	6	10	Монголын түүх, соёл, ёс заншил
7	Л.Нямхүү	Физикч, мэдээллийн технологич	докторант	15	20	Техник хангамж
8	Ж.Отгонсүрэн	Монгол хэлний багш	Доктор	1	25	Монгол хэл бичиг, найруулга зүй
9	Ц.Ундармаа	Математик, мэдээлэл зүйн багш	Магистр	10	11	Харилцааны ур чадвар I, II
10	Т.Цэрэнлахм	Физик, мэдээлэл зүйн багш	Магистр	2	10	Физик
11	О.Баярцогт	Багш, дасгалжуулагч	спортын мастер	6	6	Биеийн тамир
12	Ч.Батчулуун	хурандаа	Магистр	5	5	Гамшгийн менежмент

*Мэргэжлийн суурь хичээлийн багш нар*

№	Овог нэр	Үндсэн мэргэжил	Эрдмийн цол, зэрэг	Сургуульд ажилласан жил	Мэргэжлийн байгууллагад ажилласан жил	Заах хичээл
1	Л.Нямхүү	Физикч, технологич	Магистр	15	20	Системийн шинжилгээ ба зохиомж, UML хэл

						Мэдээллийн систем
2	А.С.Баиров	Программ хангамж	Докторант	1	4	Интернэт программчлал I Тооцон бодох математик
3	Ю.Намсрай М.Баярбилэг Т.Батзул	Математикч Программист	Магистр	10	11	Объект хандлагат програмчлал Дискрет математик Математик программчлал
4	Б.Оргилмаа	Физик, мэдээлэл зүйн багш	Магистр	11	11	Өгөгдлийн бүтэц Компьютерын сүлжээ I, II
5	Ц.Ундармаа	Математик, мэдээлэл зүй	Магистр	11	12	Алгоритмын үндэс, Програмчлалын хэл
6	М.Янжиндулам	Физик, мэдээлэл зүйн багш	Магистр	6	11	Компьютерын график, Компьютер зохион байгуулалт ассемблер хэл
7	Т.Соёлмаа	ЭТТИ инженер	Магистр	7	9	Электроникийн үндэс
8	О.Лхагварэнцэн	Эдийн засагч, нягтлан бодогч	Доктор	10	32	Бизнес төсөл
9	Б.Мөнхжаргал	Эдийн засагч	магистр	6	8	
10	Ю.Туул	Статистик	Доктор	11	32	Энтрепренёр

*Мэргэжлийн хичээлийн багш нар*

№	Овог нэр	Үндсэн мэргэжил	Эрдмийн цол, зэрэг	Сургуульд ажилласан жил	Мэргэжлийн байгууллагад ажилласан жил	Заах хичээл
1	Л.Нямхүү	Физикч, технологич	Магистр	14	19	Хүн машины харилцаа Мэргэжлийн ёс зүй
2	Ч.Ундрах		Магистр	3	9	Визуаль програмчлал

		Программ хангамжийн инженер				Интернэт программчлал II
3	М.Баярбилэг	Математикч, Программист	Магистр	9	9	Жава технологи
						Программ хангамжийн шаардлагын шинжилгээ
						Программ хангамжийн архитектурур ба чанарын үнэлгээ
4	М.Туул	Хүний их эмч	ШУ-ны доктор	14	42	Судалгааны арга зүй
5	С.Бямбасүрэн	Физик, электроникийн багш	Магистр	11	12	
6	Б.Оргилмаа	Физик, мэдээлэл зүйн багш	Магистр	11	11	Программ хангамжийн төсөл
						Байгууллагын нөөцийн систем - ERP System
7	М.Янжиндулам	Физик, мэдээлэл зүйн багш	Магистр	6	11	Пайтон програмчлалын хэл, Хиймэл оюун ухаан ба машин сургалт
8	О.Мөнгөнсүх	Программист	Магистр	11	15	Өгөгдлийн сангийн програмчлал Мэдээллийн аюулгүй байдал, UNIX үйлдлийн систем Хөдөлгөөнт холбооны програмчлал I,II
9	Д.Энхжаргал	Программ хангамж	Магистр	4	10	Системийн програмчлал
10	Э.Ононгоо	Программ хангамж	Маг-нт	3	9	Мэргэжлийн англи хэл, Үйлдлийн систем
11	Н.Долгион	Программ хангамж	Магистр	2	2	Инновац ба технологи

## Суралцагчдын тоо

Хичээлийн жил	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Нийт оюутны тоо	37	74	95	108	156	145

## Төгсөгчдийн тоо гэх мэт хөтөлбөртэй холбоотой мэдээлэл оруулах

Хичээлийн жил	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023	Нийт
Нийт төгсөгчдийн тоо	1	7	3	17	10	38

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Илрэл нотолгоо:

1. Дэлхийн эдийн засгийн форумын тайлан, дүгнэлтийн судалгаа
2. АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн товчооны мэдээ
3. Stanford, Nanyang их сургуулиудын хөтөлбөр
4. Монгол улсын цахим хөгжлийн бодлого
5. Засгийн газрын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2020-2024
6. ХНХЯ-ны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын судалгаа
7. БСШУЯ-ны дээд боловсролын шинэчлэл төслийн судалгаа
8. БШУ-ны сайдын А78, А174 тушаалууд
9. ШУТИС, МУИС-ийн хөтөлбөрийн судалгаа
10. Ажил олгогч, төгсөгчдийн судалгаа

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### **Илрэл нотолгоо:**

1. Хөтөлбөр
2. өөрийн үнэлгээний тайлан
3. Сургуулийн вебсайт

### **Онцлог зүйл:**

1. Хувь хүний хандлага, ёс зүй, хүнлэг чанар эзэмшүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөртэй (харилцааны ёс зүй, ур чадвар, эрх зүй, ёс заншил, соёл).

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

## **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

1. Хөтөлбөр, өөрийн үнэлгээний тайлан
2. Хичээлүүдийн хөтөлбөр
3. Суралцагч, төгсөгч, ажил олгогчоос авсан судалгаа, уулзалт
4. Төгсөгчдийн дипломын ажлууд

### **Онцлог зүйл:**

1. Хөтөлбөрийн 19 үр дүнг хичээл, анги бүрт хуваарилж гаргасан.
2. Программ хангамж мэргэжлээр багш, компьютерын сүлжээ, мэдээллийн систем мэргэжилтэй хослон, хөрвөх мэргэжлүүдийг хөтөлбөрийн үр дүнд тодорхойлсон.

### **Анхаарах асуудал:**

1. Багш мэргэжлээр хослон төгсөх бол заах арга зүй, мэдээллийн систем мэргэжлээр хослон төгсөх бол мэдээллийн системийн менежмент зэрэг хичээлүүдийг нэмэх

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **Зөвлөмж:**

1. АСМ олон улсын байгууллагын 2014 оны зөвлөмжийг харвал программ хангамжийн бүтээлт (construction), процесс (process), загварчлал (modeling) технологийн хичээл нэмж болохоор байна.
2. Хослон хөрвөх мэргэжлийн хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнд нэмэх



## **ШАЛГУУР 1.**

### **ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН**

#### **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

#### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### **Илрэл нотолгоо:**

1. Хөтөлбөр, өөрийн үнэлгээний тайлан
2. Хичээлүүдийн хөтөлбөр
3. Багш нартай уулзсан уулзалт

#### **Онцлог зүйл:**

1. Төслийн 4 ажил, 2 дадлагатай

#### **Анхаарах асуудал:**

1. Хичээл хоорондын холбоосыг сайжруулах

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Зөвлөмж:**

1. Хоёр дадлагын даалгавруудыг давхардуулалгүй, ялгаатай болгох, өмнө үзсэн хичээлтэй холбож тодорхой болгох, хоорондын зайг ихэсгэх

#### **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

1. Хөтөлбөр
2. Өөрийн үнэлгээний тайлан
3. Лаборатори
4. Удирдлагын мэдээллийн систем
5. Нотлох баримт 2.9 ажил олгогчийн судалгаа
6. Нотлох баримт 2.17 вебд хичээлээ байршуулдаг
7. Нотлох баримт 2.35 багш нарын даалгаврын сан

### **Анхаарах асуудал:**

1. Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд, хөтөлбөрөөр эзэмших мэдлэг чадвар, хандлагын хоорондын хамаарлын хүснэгтэнд буй алдааг засах

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **Шаардлага**

Биеийн тамир, хүний хөгжил, түүх, гамшгийн менежмент зэрэг хичээлээр эзэмших мэдлэг чадвар, хандлага нь хөтөлбөрөөр эзэмших мэргэжлийн суурь мэдлэгтэй холбогдсон байгааг засах. Гэх мэтчилэн бусад хичээлүүдийг шалгах

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

1. Хөтөлбөр
2. Өөрийн үнэлгээний тайлан
3. Хичээлийн хөтөлбөрүүд
4. Сургуулийн веб
5. Удирдлагын мэдээллийн систем
6. Төгсөгчдийн дипломын ажил

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

## **ШАЛГУУР 2.**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ:** БҮРЭН ХАНГАСАН

## **ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

1. Сургуулийн хичээл байр, анги танхим, лаборатори, оюутны дотуур байр, бассейн, спорт заал, оюутны чөлөөт цагийн өрөөнүүд, гуанз
2. Сургуулийн сүлжээ, дэд бүтэц, сервер тоног төхөөрөмжүүд
3. Багш нартай уулзсан уулзалт, багш нарын өрөө

### **Онцлог зүйл:**

1. Хичээлийн 6 байр, оюутан сурах, багш ажиллах орчин нөхцөл, тохижилт сайн.
2. Сургалтын лаборатори хүрэлцээтэй
3. Оюутны чөлөөт цагийн тохилог өрөөнүүд, усан бассейн, спорт заал
4. Оюутны дотуур байр амьдрахад таатай нөхцөлтэй

### **Анхаарах асуудал:**

1. Дотуур байранд интернет, wifi сүлжээ тавих
2. Notebook-тэй оюутнуудад зориулсан цахилгааны разетка, сүлжээ, нэмэлт дэлгэц бүхий ширээг коридор, вестульд тавих

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **Зөвлөмж:**

1. Сүлжээний хүртээмжийг сайжруулах, сүлжээнд зохисгүй агуулгыг филтер хийх технологи шаардлагатай бол нэвтрүүлэх
2. Оюутны notebook хэрэглэх чиглэлийг илүү анхаарах, үүнтэй холбоотой компьютерын лабораторид компьютер худалдан авах хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэж үүнийгээ Apple лаборатори байгуулах тусгай зориулалтын лабораторид зарцуулах

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

1. Сургуулийн лаборатори, компьютер, программ хангамж

### **Онцлог зүйл:**

1. Удирдлагын мэдээллийн системийг сургалтын бүх процесстoo хэрэглэж хэвшсэн, сайн хэрэглэдэг, оюутнууд цахим агуулгатай танилцан цаг хугацаа болон орон зайнаас хамааралгүй сурах нөхцөл бүрдсэн.
2. Удирдлагын мэдээллийн системийн эх кодыг хөгжүүлэгчээс худалдан авч цаашид өөрсдөө хөгжүүлдэг багийг бүрдүүлж хөгжүүлж байгаа

### **Анхаарах асуудал:**

1. Зарим цөөн хичээлийн цахим контент дутуу эсвэл байхгүй.
2. Mobile, iOS, Mac OS X хөгжүүлэлт хийхэд Apple-н тусгай зориулалтын лаборатори байхгүй
3. Линукс зэрэг нээлттэй эхийн үйлдлийн систем лабораторийн компьютеруудад суулгаагүй.

**Үнэлгээ:** Хэсэгчлэн хангасан

### **Зөвлөмж:**

1. Сүлжээний хүртээмжийг сайжруулах, сүлжээнд зохисгүй агуулгыг филтер хийх технологи шаардлагатай бол нэвтрүүлэх
2. Оюутны notebook хэрэглэх чиглэлийг илүү анхаарах, үүнтэй холбоотой компьютерын лабораторид компьютер худалдан авах хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэж үүнийгээ Apple лаборатори байгуулах тусгай зориулалтын лабораторид зарцуулах

### **Шаардлага:**

1. Хичээлийн цахим контентийг гүйцээх
2. Лабораториудад Линукс үйлдлийн систем давхар суулгах

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

1. Номын сан, фронт, номын сангийн программ

#### **Онцлог зүйл:**

1. Номын сангийн орчин нөхцөл, тохижилт сайн

